

ЗҮҮН ХОЙД АЗИЙН ДЭД БҮТЦИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ТӨЛӨВ

*Ц.Баатар**

Ийм сэдэвтэй олон улсын эрдэм шинжилгээний нэгэн хурал Өмнөд Солонгосын нийслэл Сөүл хотноо энэ оны есдүгээр сарын 7-9-нд болж өнгөрлөө. Хурлыг Өмнөд Солонгосын Үндэсний Нэгдлийн Солонгосын Хүрээлэн зохион байгуулав. Эрдэм шинжилгээний хуралд ОХУ, Хятад, Япон, АНУ, Монгол, Өмнөд Солонгосын судлаачид болон экспертүүд оролцож, Зүүн хойд Азийн аюулгүй байдал, хамтын ажиллагаа, эдийн засгийн интеграци, дэд бүтцийн хөгжлийн асуудлаар шинэ, шинэлэг санаа дэвшүүлсэн олон сонирхолтой илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Глобалчлалын өнөөгийн эринд ЗХА-ийн бүс нутгийн орнуудын хооронд улс төр, аюулгүй байдал, эдийн засаг, соёлын харилцан хамаарал улам бүр өсөн нэмэгдэж байгааг илтгэлүүдэд тэмдэглэж байв. Түүнчлэн бүс нутгийн орнуудын хооронд итгэлшлийг бэхжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд бүсийн орнуудын улс төр, бизнесийн хүрээнийхэн, төрийн бус байгууллага, судлаач, шинжээчдийн болон хүмүүс хоорондын харилцаа чухал хүчин зүйлийн нэг гэж үзэж чухал ач холбогдол өгч байлаа.

Судлаач, шинжээчид Зүүн хойд Азийн бүс нутаг гэдэг ойлголтод ч шүүмжлэлтэй хандаж байсныг энд дурдахад илүүдэхгүй биз ээ. Орон бүр энэ талаар өнөө хир өөр өөр ойлголттой, өөр өөрийнхөөрөө явдаг нь цаашдын хамтын ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэсэн анхааруулга ч сонсдож байв. Өмнөд Солонгосын тал газар зүйн хувьд Зүүн хойд Азийн бүс нутагт хоёр Солонгос, Хятад, Япон, Орос, Монгол орж байгаа нь нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн асуудал гэж үздэг аж. Үүний сацуу энэ бүс нутгийн хувьд олон хүчин зүйлсийг харгалзан үзэж дээрхи орнууд дээр нэмж АНУ, АСЕАН-ыг хамруулж үздэг байна.

Эрдэмтэд энэ тал дээр хэдийгээр өөр саналтай байсан хэдий ч бодит байдлыг үндэслэн үүнийг хүлээн зөвшөөрч байлаа. Учир нь Японы эрдэмтэд сүүлийн үед Зүүн Азийн номлолыг олон улсын хэмжээнд хүчтэй тавьж байгаа. Тэр нь нэлээд хүч авч байгаа тул ЗХА-ийн бүрэлдэхүүнд АНУ, АСЕАН-ыг оруулах болсон нь зүйн хэрэг биз ээ.

Ер нь ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагаа Зүүн Азийн хүрээнд л амжилттай хэрэгжинэ гэдэгт эрдэмтэд санал нэгдэж байв.

Зүүн хойд Азийн дэд бүтцийн хамтын ажиллагааны хувьд олон талын асуудлыг хамруулан тал бүрээс нь нухацтай авч үзэж өргөн хүрээнд хэлэлцлээ. Тухайлбал, дэд бүтцийн бодлогын асуудлыг

*Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

хэлэлцэхэд энэ талаархи хоёр болон олон талын яриа хэлцээ, бодлогын адил төстэй болон ялгаатай тал, системийн ялгаа, орон нутгийн бодлогын хязгаарлалт гэж юу болох тухай онолын асуудлыг хөндөж, асуудал дэвшүүлж байх жишээтэй.

Эдийн засгийн дэд бүтцийн асуудлыг ярилцахад санхүү, худалдаа, хөрөнгө оруулалтын хүрээний асуудлаас гадна Чөлөөт Худалдааны Гэрээний талаар ч хөндөгдөв.

Дэд бүтцийн аюулгүй байдлын хүрээнд цэрэг батлан хамгаалахын болон цэргийн холбоо нэгдэл, аюулгүй байдлын хоёр талын хамтын ажиллагаа, бүс нутгийн орнуудын хоорондох маргаантай асуудал, зөрчил, түүний уг сурвалж, аюулгүй байдлын олон талт хамтын ажиллагааны чиглэлд гарч буй нааштай алхам, бүс нутагт олон улсын цэрэг армийн хяналт, түүний үүрэг роль зэрэг өргөн цар хүрээтэй асуудлуудыг хамруулан авч үзэж энэ чиглэлээр эрдэмтэн судлаачид санал бодлоо чөлөөтэй солилцов.

Соёлын дэд бүтцэд бүс нутгийн орнуудын соёлын нийтлэг ба ялгаа, соёлын солилцоо, хамтын ажиллагааны өрнөл хөгжил, аялал жуулчлалын асуудлуудыг энэ хүрээнд хамруулан авч хэлэлцэв.

Эрдэмтдийн тавьсан илтгэлээс АНУ-ын Харвардын их сургуулийн профессор Доуг Бондын тавьсан “Зүүн Хойд Азийн хамтын ажиллагаа, харилцан үйлдэл, өсөлт хөгжилт: Эмпирик судалгаа (2000-2004)” гэсэн илтгэл олны анхаарал сонирхлыг ихээхэн татлаа. Уг илтгэлийг бэлтгэхдээ 1990-2004 оны хооронд олон улсын нэр хүндтэй хэвлэлд ЗХА-ийн орнуудын хоёр болон олон талт харилцаа, хамтын ажиллагааны талаар нийтлэгдсэн 10,2 сая үйл явдлын мэдээллээс сонголт хийж 3 692 809 үйл явдлын мэдээллийг түүвэрлэн авч, тоон утганд хөрвүүлэн эмпирик судалгаа хийж судалгааны үр дүнг графикаар харуулсан байна. Уг илтгэлийн талаар үг хэлсэн судлаачид урд өмнө энэ чиглэлээр ийм судалгаа гараагүй, цоо шинэ туршилт, шинэ ойлголт, шинэ гаргалааг энэ судалгаа бидэнд өглөө хэмээн чухал ач холбогдол өгч өндөр үнэлж байлаа.

Японы Хирошима хотын их сургуулийн Хирошима Энхтайвны институтын профессор, солонгос гаралтай Ким Сан Чул “Зүүн Хойд Азийн бүс нутгийн хамтын ажиллагаа ба дотоод түгжигдмэл сэтгэлгээ” гэсэн сонирхолтой илтгэл тавьж хэлэлцүүлэв. Илтгэлд бүс нутгийн орнуудын дотоод бодлого, түүний хувьсал хөгжил бүсийн хамтын ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг ултай авч үзжээ. Илтгэгч Зүүн хойд Азийн орнуудын дотоод бодлогын үзэл баримтлал, хувьсал өөрчлөлтийг Энэтхэг, Турк, Бангладеш, Өмнөд Африк, Пакистан, Хятад, Япон, АНУ, ОХУ, Англи, Франц, Итали, Холбооны Герман зэрэг оронтой харьцуулан авч үзээд энэ нь бүсийн хамтын ажиллагаанд

хэрхэн нөлөөлж байгааг харуулжээ. Тэрээр бүс нутгийн хөгжил урагш ахихгүй байгаа нь бүс нутгийн орнуудын дотоод бодлого, үйл ажиллагаатай нягт холбоотой гэсэн дүгнэлт хийжээ.

“ЗХА-ийн дэд бүгчийн хамтын ажиллагаанд Орос улсын байр суурь” сэдвээр Оросын Дэлхийн эдийн засаг, олон улсын харилцааны хүрээлэнгийн судлаач Александр Педоровский илтгэл тавьж хэлэлцүүлээ. Орос “ах” бүсийн эдийн засгийн хамтын ажиллагаа, өөр хоорондоо хэрхэн харилцан хамааралтай болж буй талаар ярихдаа гол төлөв Хятад, Япон, Өмнөд Солонгостой Орос улсын худалдаа, эдийн засгийн харилцааны жишээн дээр тодорхой авч үзээд цаашдын хандлагын талаар чухал санаа дэвшүүлж байлаа. Манай улс Оросын хувьд дэндүү жижиг санагдсан уу, эсвэл энэ талаар сонирхоогүйнх юм уу илтгэгч Монголын талаар юу ч дурдсангүй нь миний хувьд анхаарал татаж байлаа. Монголын хувьд ямар бодолтойг нь сонирхож асуухад бидний сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагаа тодорхой шүү дээ гэсэн бүрхэгдүү хариу өглөө.

Төгсгөлийн хуралдаан дээр Өмнөд Солонгосын талаас Ерөнхийлөгчийн дэргэдэх Зүүн Хойд Азийн Хамтын Ажиллагааны Санаачлагын Хорооны дэд захирал Ли Жон Хо, Үндэсний Нэгдлийн Солонгосын хүрээлэнгийн салбарын захирал Пак Жон Чул нарын тавьсан илтгэлд Зүүн хойд Азийн аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагааг ургашлуулахад Өмнөд Солонгосын тавьж буй хүчин чармайлт, баримталж буй байр суурийг олон талаас нь шинжлэн дүгнэж, түүнд Өмнөд Солонгосын гүйцэтгэх үүрэг ролийн талаар өргөн дэлгэр ойлголт өгөхөд чиглэжээ. Түүнчлэн ЗХА-д бий болоод байгаа зөрчил, цөмийн зэвсгийн асуудал, хоёр Солонгосын асуудал түүнд Өмнөд Солонгосын тавьж буй хүчин чармайлт өнөөгийн байдал, цаашдын төлвийн талаар илтгэлд тодорхой тусгажээ. Өмнөд Солонгосын тал Солонгосын хойгийн цөмийн зэвсгийн асуудлаар болж буй 6 талт хэлэлцээрт Монгол Улсыг оролцуулах боломжтой. Түүнд оролцох орны нэг гэж үзэж байгаагаа илэрхийлсэн нь Солонгосын талын гаргасан шинэ санаа байлаа. Үүнийг сонссон АНУ-д төвлөдөг Олон улсын хямралын группын (International Crisis Group)-ын Өмнөд Солонгос дахь салбарын захирал Петр М.Бек Монголын тал хэлэлцээнд нөлөөлж чадна гэхэд итгэхгүй байна. Та юу гэж бодож байна гэж надаас асуухад, шууд нөлөө үзүүлэхгүй ч гэсэн дам байдлаар нөлөөлж болох юм. Хойд Солонгостой манай улс 50 гаруй жилийн найрсаг харилцаатай гэсэн хариулт өгөв.

Тус хуралд оролцсон миний бие “Зүүн Хойд Азийн аюулгүй байдал, хамтын ажилгаанд Монгол Улсын баримталж буй байр суурь” гэсэн илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Илтгэлтэй холбогдуулан Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд хоёр хөрштэйгээ харилцах харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгнө гэсэн мөртлөө танай улс АНУ тийш хэт хэлбийж байгаа юм биш үү?. Ялангуяа цэрэг, батлан хамгаалахын хувьд Америктай бүр ч их холбоо сүлбээтэй болоод байгаа юм биш үү? Мянганы зам мөрөөдлийн зам уу, бодит зүйл үү? Хойд Солонгосоос ажиллах хүч авах санал танай Ерөнхийлөгч тавьсан, энэ хэр үндэслэлтэй вэ?, Дорнод Монголд танай гол баялаг байдаг гэсэн мэдээлэл олонтаа сонссон. Энэ чиглэлээр хийсэн бодит судалгаа байна уу? гэх мэт олон асуулт гарч байлаа. Дээрхи асуултаас зарим улс төрийн өнгө аястай асуултын хариултын утгыг товчлон сийрүүлэе.

Монгол, Америкийн харилцааны талаар хоёр хөршөөс анхааруулан сануулсан зүйл өнөө хэр бидэнд байхгүй. Монгол Улс нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогын үзэл баримтлалын хүрээнд АНУ-тай харилцдаг. Энхийг сахиулах үйлсэд оролцох цэрэг дайчдын сургалт, боловсон хүчин бэлтгэх зэргээр цэрэг армийн салбарт хязгаарлагдмал хүрээнд хамтран ажилладаг. Мэдээж хэрэг эдийн засаг, соёлын өргөн харилцаатай. Шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлийг даван туулахад бодитой тусламж дэмжлэг үзүүлж буй орны нэг нь АНУ. Монгол Улс АНУ-ын Мянганы Сорилтын Сангаас тусламж авах орны нэгэнд шалгарсан. Монгол Улс АНУ-тай Чөлөөт Худалдааны Хэлэлцээр байгуулах талаар хүчин чармайлт тавьж байгаа. АНУ-ын тал ч нааштай хүлээн авч байгаа. Монгол Улсын хувьд нэг тийш хэт хэлбийсэн зүйл байхгүй болов уу гэж би бодож байна. Хоёр хөрштэйгээ эн тэнцүү харилцаж түүнд тэргүүлэх ач холбогдол өгч харилцаж буй байр суурь хэвээр гэсэн хариулт өгсөн. Хойт Солонгостой харилцах харилцаанд Америк зарим улс төрийн өнгө аястай чиглэл өгдөг үү? гэсэн асуулт ч гарч байлаа. Манай улс аль нэг улсын заавар зөвлөмжөөр нөгөө улстай харилцаж ирсэн үе нэгэнт өнгөрсөн. Хойд Солонгосын цөмийн зэвсгийн асуудлаархи 6 талт албан бус сувагт Монголыг оролцуулах саналыг Америкийн тал тавьсан гэж баттай эх сурвалжаас сонссон гэсэн хариулт өгсөн гэх мэтээр тэдний сонирхсон асуудалд өөрийн ойлголтын хэмжээнд хариулт өглөө.

Хуралдааны завсарлагаагаар дээр өгүүлсэн Ерөнхийлөгчийн дэргэдэх ЗХА-ийн Хамтын Ажиллагааны Санаачлагын Хорооны Монголын асуудлыг хариуцсан бололтой албаны хүмүүс хүлээн авч уулзалт хийсэн. Тэд Монгол, Солонгосын харилцааны өнөөгийн хүрсэн түвшин, цаашид анхаарах асуудлын талаар нэлээд сонирхож харилцан ярилцсан. Тэд манай талаар нарийн судалгаа, мэдээлэлтэй байдаг нь асуулт нэг бүрээс нь харагдаж байлаа. Тэд гол төлөв олсон мэдээллээ нягтлах, баталгаажуулах, Монголын судлаачын байр суурийг тандах, Солонгосын бизнесменүүдийн талаар монголын олон нийтийн санаа

бодол ямар байгаа, Орос, Хятад хоёр хөрштэй харилцаж буй худалдаа эдийн засгийн харилцаанд ямар өөрчлөлт гарч байгаа, Европын Холбоонд татваргүй гарах 7200 нэр төрлийн барааны зарим нэгийг Солонгосын талаас Монголд үйлдвэрлэж Европын Холбоонд гаргах боломж нөхцөл байх эсэх олон асуулт тавьж байлаа.

Дээрхи асуултуудад товч хариулт өгөөд хоёр орны харилцаанд цаашид анхаарвал зохих зүйлийн талаар солонгос нөхөдтэй санал бодлоо илэн далангүй хуваалцлаа. Тухайлбал, өнөө хэр Солонгосоос Монголын эдийн засгийн өсөлт хөгжилд нэмэр болох стратегийн чанартай хөрөнгө оруулалт бараг алга. Хөрөнгө оруулагчид гол төлөв амиа аргацаасан жижиг бизнес эрхэлж байна. Тэд бар, ресторан ажиллуулах төдийхнээр хязгаарлагдах боловч голдуу эмс охидыг садар самуунд уруу татах хандлага давамгайлж байна. Солонгостоо орох оронгүй зуугуул мафийн болон гэмт хэргийн элементүүдийн эцсийн орогнох газар Монгол боллоо. Тэд хөрөнгө оруулагч нэрээр орж ирээд юм үзээгүй гэнэн цагаан монголчуудад орон сууц барьж өгнө, Солонгосын виз найдвартай гаргаж өгнө, толгой эргэм их хөрөнгө оруулалт хийнэ гэх мэтээр залилангийн гэмт хэрэг их хийж байна. Энэ нь олон нийтийн жигшил дургүйцлийг ихээхэн төрүүлж байна. Солонгосын төр засгаас энэ тал дээр анхаарахгүй бол харилцаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Солонгосын ард түмэн зовлон бэрхшээлийг богино хугацаанд даван туулж өнөөгийн өндөрлөгт хүрсэн. Энэ нь Солонгосын ард түмний цуцалтгүй нөр их хөдөлмөр, хүчин зүтгэлийн үр дүн гэдэгт монголчууд бид үзэж үргэлж бахархаж байдаг. Өнөөгийн өндөрлөгт хүрэхэд та бүхэн эхлээд юунд анхаарч, яаж хөл дээрээ зогссон, тийм талын тусламж бидэнд өнөөдөр чухал байна. Миний олж мэдсэнээр танай улс гадаадын хөрөнгө оруулалтыг экспортын чиглэлийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд голлон татаж төрөөс бодлогоор дэмжин зохицуулж ирсэн байдаг. Та бүхэн Монголд стратегийн чанартай хөрөнгө оруулалт хийх бол манай дэд бүтэц, мэдээллийн технологи, экспортын чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, уламжлалт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд гүн боловсруулалт хийх, оюуны багтаамж шингэсэн экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, Монголд логистик төвүүдийг байгуулах, Монголын залуу үеийнхэнд мэдээллийн техник, технологи эзэмшүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр дорвитой, бусад улс орнуудад үлгэр болохуйц, өрсөлдөөн бий болохуйц хөрөнгө оруулалт хийж үр дүнтэй, бодитой тусламж дэмжлэг үзүүлэх явдал бидэнд өнөөдөр юу юунаас чухал байна. Түүнээс бус хэдэн валютын юм уу эд зүйлсийг бэлгийн, хандивийн шугамаар тараах гэх мэт нь үр нөлөө багатай гэсэн санаа илэрхийлсэн.

Шинжлэх ухааны салбарт хөрөнгө оруулалт хийж төсөл хэрэгжүүлэх олон чиглэлүүдийн нэгэнд “Зүүн хойд Азийн интеграци”-ыг ургашлуулахад чиглэсэн хамтын ажиллагааны төсөл байж болох байна. Түүнийг гардан хариуцаж, хамтран ажиллах боломж манай хүрээлэнд бий гэсэн санаа хэлсэн. Түүнчлэн Монгол Улсад шороон шуурганы аюул нүүрлээд байгаа. Энэ нь ганц Монголын асуудал бус ЗХА-ийн бүх орны, цаашлаад дэлхий нийтийн асуудал болоод байна. Манай засгийн газар “Ногоон хэрэм” хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Танай оронд ирээд харж байхад цул хаднаас хүртэл мод ургасан харагдах юм. Энэ чиглэлд анхаарна уу. Амархан ургадаг, хөрс голдоггүй, ганд тэсвэртэй тарьц суулгац юу байна. Энэ чиглэлд төсөл хэрэгжүүлбэл үр ашигтай байх гэсэн санаа хэлсэн. Мөн Монгол Улс Солонгос улстай Чөлөөт Худалдааны Гэрээ байгуулах сонирхолтой байгаа талаар яриад үүнд зарим тодотгол хийхийг оролдсон. Тухайлбал, Монголын хөгжлийн түлхүүрийг хоёр хөрш маань атгадаг. Зүүн Азиас орох бүх бараа Хятадыг, Европ зүгээс орж ирэх бараа Оросыг дамждаг. Хоёр хөршөөс энэ талын тээврийн, тарифын болон тарифын бус хориг саадыг чөлөөлөхөд л Монгол Улс өсөлт хөгжлийн замд гарах бас нэгэн өргөн боломж нээгдэх учиртай. Одоохондоо тийм боломж бидэнд олдохгүй байгаа учраас эхний ээлжинд бус нутгийн хамгийн өргөн дэлгэр, ойр дөт харилцаатай, байнга туслан дэмжиж байдаг Япон, Өмнөд Солонгос хоёр улстай Чөлөөт Худалдааны Гэрээ байгуулах сонирхолтой байгаа юм гэдэг тодотгол хийсэн.

Товч санаануудаа тоймлон өгүүлэхэд ийм байна. Зарим нэгнийх нь инээд ч хүрч болох. Бодлого боловсруулагч шиг юун ч илүү дутуу юм донгосдог юм билээ. Хирээ мэдэхгүй гэх мэт. Гэвч тэд асуусан. Юу хүсэж бодож явдагаа хэлэхийг хүссэн. Энэ чиглэлээр чамгүй олон жил хоол хороож, хүрээлэнгээ төлөөлж олон улсын чанартай хуралд тогтмол оролцож, санал бодлоо солилцож ирсний хувьд хувийн санаа бодлоо илэрхийлсэн хэрэг. Түүнээс бус аль нэг түшмэлийн байр суурийг энд илэрхийлээгүй болохыг ухаант мэргэд болгооно биз ээ. Энэ дашрамд нэгэн зүйлийг тэмдэглэхэд гадны эрдэмтэд зөвлөхдөө та нар өөрийгөө бусдад ойлгуулах, мэдрүүлэхийн тулд олон улсын чанартай арга хэмжээнд бүх түвшинд бүхий л чиглэлээр аль болох тогтмол оролцож тэднийг өөртөө татах, илүү өргөн сурталчилах тал дээр анхаарах хэрэгтэй. Нэг юм нүдэнд үзэгдэж гарт баригдаж ижил дасал болтол цаг хугацаа шаардана. Тийм учраас Монголоо таниулах тал дээр илүү их анхаармаар санагддаг гэж байлаа. Анхаарууштай л зөвлөгөө болов уу.

Эцэст нь хурлын явцаас үүдсэн санаа бодлоо илэрхийлье. Монгол Улс өнгөрсөн зууны 90-ээд оны эхнээс Зүүн хойд Азийн чиглэлд чухал ач холбогдол өгч, гадаад бодлогын үзэл баримтлалдаа тусгаж, бие

даасан судалгааны төв хүртэл байгуулсан. Гэтэл шинэ зуун гарсаар энэ асуудал бараг унтарч байна уу даа гэсэн бодол төрөх юм. Учирлаваас байгуулсан төвөө татан буулгасан. Одоо энэ чиглэлийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулсан ямар нэг функц манайд хаана ч байхгүй болжээ. Судалгаа ч зогсчээ. Баабарын Зүүн хойд Азийн нийгэмлэгээс өөр ийм чиглэлийн байгууллага алга.

“Монголын хөгжлийн судалгааг дэмжих төв” хэмээх төрийн бус бие даасан судалгааны байгууллагын тэргүүн, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн манай нэртэй судлаач, дипломатч Цэдэндамбын Батбаярын санаачлага, хичээл зүтгэл, Японы Сасакава Энхтайвны сангийн санхүүжилтийн ач буянаар “Зүүн хойд Азийн энхтайван тогтвортой хөгжилд Монгол Улсын гүйцэтгэх үүрэг роль” гэсэн төслийг 2001 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Монголын хөгжлийн тулгамдсан асуудлаар манай нэртэй судлаачдыг татан оролцуулж судалгаа хийлгэж, ЗХА-ийн аюулгүй байдал, хоёр болон олон талт хамтын ажиллагаа, ядуурлыг бууруулах, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэд бүтцийн хөгжил зэрэг өргөн цар хүрээтэй асуудлыг хамарсан Олон улсын эрдэм шинжилгээний 10 орчим хурал, уулзалт, семинар зохион байгуулж, хурлын материал, судалгааны ном товхимол хэвлүүлж, судлаачид болон сонирхогч өргөн олны хүртээл болгож, энэ талын судалгааны доголдлыг ямар нэгэн хэмжээгээр нөхөж ирлээ. Энэ төсөл ирэх онд дуусна. Үйл явдлын өрнөлтөөс ажиглаж байхад бүс нутгийн орнууд энэ талын судалгаанд түлхүү ач холбогдол өгч, олон тооны судалгааны байгууллага байгуулж түүнд ажиллах хүний нөөцийн асуудлыг төрийн бодлого, зохицуулалтаар хэрэгжүүлж, аж ахуй, санхүүгийн хувьд бэхжүүлж байна. ЗХА-ийн орнуудын төр засгийн төв байгууллагын дэргэд энэ чиглэлээрхи бодлогын зөвлөмж боловсруулдаг Think Tank юм уу тусгай хороо ажиллуулдаг юм байна. Солонгос, Хятад гэхэд л бараг их сургууль болгоны дэргэд судалгааны хүрээлэн, төв ажиллуулж байна. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэй Түмэн голын сав газрыг хөгжүүлэх төслийн хугацааг энэ оны есөн сард дахин 10 жилээр сунгаж баталгаажууллаа. Энэ бүхнээс үүдэн хэрэв Монгол Улс Зүүн хойд Азид өрнөж буй үйл явцад идэвхитэй оролцох шаардлагатай гэж үзэж байгаа бол хугацаа алдахгүй бие даасан судалгааны нэгж байгуулах зайлшгүй шаардлага урган гарч байна.

Судлаачдын залуу халааг бэлтгэдэг систем тогтолцоог ч манайд эргэж харахгүй бол тун удахгүй эмгэнэлт байдалд орж болзошгүй болжээ. Олон орны туршлагаас харж байхад тухайн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтдэд шавь сургууль нээх эрх олгож, эрх авсан эрдэмтэд тухайн салбарыг цаашид аваад явах шавиа олон шалгуураар сонгон авч уйгагүй ажилладаг. Түүнийг нь төрөөс санхүүжүүлж

бодлогоор бэлтгэдэг уламжлалт систем бий. Манайхан үүнийг мэдэхийн дээдээр мэдэж байгаа ч нүдэн балай, чихэн дүлий явж, зоосны нүхээр бүхнийг шийдэж байна. Хүссэн сургууль бүр дэргэдээ магистр, докторын сургалт явуулдаг. Наад захын шалгуур даадаггүй ч зоосны нүхээр харж, мөнгөний хойноос улайран “эрдэмтэн”, “судлаач” бөөнөөр үйлдвэрлэдэг өвөрмөц гаж буруу тогтолцоотой орон ганцхан Монгол. Зүй нь гадна, дотно хаана ч хүлээн зөвшөөрөгдөхүйцээр бэлтгэгдсэн, төгссөн л бол хаа ч нүүр бардам ажиллах ур чадвартай, олон улсын стандартын түвшинд хүрсэн сургалт явуулж, мэргэшүүлдэг бол хоёр гараа өргөөд хүлээн зөвшөөрч, дэлхийд гайхуулахаас яахав. Тийм бол хэдэн зуун их сургууль, хэдэн зуун мянган эрдэмтэн байхад юу нь буруу байх вэ. Одоо манай их дээд сургууль төгсөгчдийн ихэнхи нь үйлчлэгч, худалдагч, жолооч хийгээд явж байгаа шүү дээ. Ажлын байрны зар харжээ суухад үйлчилгээний ажилд авна гэсэн зар мэдээнд “дээд сургууль төгссөн” гэсэн тодотгол заавал хавчуулах болж. Монгол маань мөн ч лут байгаа биз. Үнэн байдал ийм л байна.

Буурай хөгжилтэй, цөөн хүн амтай, жижиг эдийн засагтай атлаа 200 орчим их дээд сургуультай, тэр нь гол төлөв төрийн түшээдийн мэдэлд байдаг, түүгээрээ бизнес хийж түмний хүүхдийг төөрөгдүүлж онигоонд орсон орон дэлхийд ганцхан Монгол. Саяхан ШУА-ийн Ерөнхийлөгчийн урилгаар Монгол Улсад айлчилсан Швейцар улсын иргэн, Нобелийн шагналт, нэрт эрдэмтэн, профессор Ричард Эрнест гуайн “Монгол шиг оронд ганцхан их сургууль байхад хангалттай” гэсэн гашуун үнэнийг төр засгийн түшээд маань цаг хугацаа алдалгүй ухаарч сэрмээр, бодмоор, зохицуулмаар юм даа.